



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/725.

Булган сум

**Мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг  
түр хугацаагаар хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ;

1.Аймгийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар мотоциклтой хөдөлгөөнд оролцогч холбогдсон 10 осол бүртгэгдэж, 2 хүн нас барж, 3 хүн гэмтжээ. Улирал, цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан улсын болон орон нутгийн чанартай авто замын нөхцөл байдал хүндэрч, зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан, халтиргаа гулгаа үүсэх, цаг агаар хүйтэрсэн нөхцөлд мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, амь насанд учирч болох хор хохирол, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан захирамжид тусгагдсан үйл ажиллагааны үр дүнг аймгийн Засаг даргад 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор танилцуулахыг Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

8374011039